

Ч.Найдансүрэн

МУИС-ийн Улс төр судлалын докторант

Даяарчлалыг эсэргүүцэгчдийн хөдөлгөөний тухай.

Өгүүллийн товч утга: Даяаршиж буй дэлхийн ертөнц, түүний эерэг, сөрөг талыг харьцуулан шинжилж хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа глобаль асуудлууд

Даяаршил гэдэг нь дэлхий дахины амьдрал хөгжил нийтлэг, түгээмэл нэг чиг хандлагатай болно гэсэн утга санааг агуулж байдаг хэдий боловч, бодит байдал дээр том гүрэн ба бага буурай орнуудад даяаршлын үзэл баримтлал, үр дагавар харилцан адилгүй тусч байна. Ялангуяа хүчирхэг гүрнүүд өөрийн эдийн засаг, нийгмийн хэв загвар, соёлын онцлогоо дэлхий дахинд түгээн тархаах бодлого явуулж байгаад олон нийтийн оролцооны байгууллагууд болон жирийн олон түмэн дүргүйцэн эсэргүүцлийн жагсаал цуглаан зохион байгуулсаар байна. Вашингтон, Прага хотод /1999, 2000он/ мөн өөр бусад олон газруудад эсэргүүцлийн жагсаал, цуглаан гарч байна. Энэ нь хөгжилтэй том гүрнүүд хүчээр түрээ барьж бусад бага буурай орныг өөртөө татаж нөлөөлөх уламжлалт бодлого, арга хэлбэр эдүгээ дэлхий нийтэд төдийлөн таашаагдахгүй байгааг илэрхийлж байна.

Даяарчлалыг эсэргүүцэгчдийн хөдөлгөөн түргэн хугацаанд олон түмнийг хамарч, үйл ажиллагаа нь идэвхжиж байгаад олон улсын шинжээчид анхаарлаа хандуулах боллоо. Генуя дахь "Их найм"-ын дээд хэмжээний уулзалтын үеэр даяарчлалыг эсэргүүцэгчдийн үйл ажиллагааны цар хүрээ, зохион байгуулалтын түвшин, мөрийн хөтөлбөрийн шинж чанар зэргээс үзэхэд уг хөдөлгөөн олон улсын улс төрийн амьдралын бодит нэгэн хүчин зүйл болсныг илтгэж байна.

Хүн төрөлхтний соёл иргэншил даяарших явцад дэлхийн ихэнхи улс үндэстний амьдрал, нийгэмд дэлгэрсэн дэвшилттэй зүйлс олон боловч бас даяарших, даяарчлах үзэгдлийн хар сүүдэр, аюул заналыг ч үгүйсгэхийн аргагүй. Эдүгээ дэлхий даяар аюулт өвчин ДОХ /дэлхийн хэмжээгээр 40 гаруй сая хүн энэ өвчний халдвар тээж байна/ дэлгэрч, хүн төрөлхтний амьдралд алан хядах аюул занал, хүчирхийлэл, мафи, хар тамхи, мансуурах бодис, өлсгөлөн гуйланчлал, ядуурал, дайн дажин, самуун газар авч, байгаль-экологийн хямрал гүнзгийрч байна.

Ази, Африкийн орнуудтай харьцуулахад хөгжлийн ерөнхий хандлага, амжиргааны өндөр боломжтой гэгдэх Европын зарим оронд ч амьдралын түвшин зогсонги байдалд орж, нийгмийн асуудлууд ээдрээтэй болсон нь даяарчлалын эсрэг үзэл өргөжих шалтгаан болж байна хэмээн нэр хүнд бүхий улс төрчид үзэж байна. Түүнчлэн, үндэстэн дамнасан компаниудын (ҮДК) хүмүүнлэгийн болон байгалийн эсрэг сөрөг үр дагавартай үйл ажиллагаанд дургүйцэх явдал, дэлхийн эдийн засагт ажиглагдаж буй хямралын шинж тэмдгүүд улам ихээр сэтгэл түгшээх болсон зэргийг онцолж байна.

Нөгөө талаар улс төр, эдийн засгийн хүрээн дэх даяарчлалын үйл явцад нийцүүлсэн АНУ-ын зонхилох үйл ажиглагаа, америкийн соёлын түрэмгийллийг далдуур эсэргүүцэх явдал бас нэг гол шалтгаан болж байна. Үнэхээр ч шинэ эрин зууны даяаршилтад АНУ тэргүүлэх хүчин болж байгааг америкийн улс төрчид, судлаачид омог бардам хэлж, ярьж байна. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга асан З. Бженский "Аугаа их шатрын хөлөг" номондоо "... Одоо Америк гэдэг дэлхийд манлайлагч цорын ганц гүрэн болж үлдсэн, Америкийн соёл дэлхий дахинд илт хол давуу тасарсан" гэж бичжээ. Иймэрхүү үзэл санаан дээр дөрөөлсөн америкийг шүтэх, түүнийг даган дуурайх нэг туйлт ертөнц гэсэн үзэл баримтлал бас байдаг.

Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, шинжлэх ухааны хүрээн дэх нэр хүнд

бүхий хүмүүс даяарчлалыг эсэргүүцэх хөдөлгөөний гол цөмийг бүрдүүлж, доороос залуучууд, ялангуяа сүүлийн үед дунд давхаргынхан нэгдэх болсноор уг хөдөлгөөний цар хүрээ аажмаар тэлж, өргөжих хандлагатай байна. Хүн амын дундах улс төрийн идэвхтэй хэсэг неолиберал чиглэлийн үйл ажиллагаанд урам хугарч, даяарчлалын үйл явц дэлхийн санхүүгийн олигархи болон ашиг хонжоо хайгч капиталуудын найруулгаар бус иргэний нийгмийн хяналтан дор хөгжих ёстой гэсэн байр суурийг онцолж байна.

Даяарчлалыг эсэргүүцэгчдийн уриа лоозонгийн гол агуулга нь урьд коммунист болон социал-демократ намууд зонхилж байсан улс төрийн тэрхүү орон зайд нэвтрэх, мөн "ногоонтнууд", сайн санааны байгууллагууд, үйлдвэрчний эвлэлүүд болон шашны нэгдлүүдийн дэмжлэгийг хүлээх боломжийг тэдэнд олгож байна. Тэдний мөрийн хөтөлбөрийн зарим заалтууд олон улсын корпорациудаас хамааралтай болсон улс үндэстнүүдийн оршин тогтнохуйн аюул заналыг даяарчлалын үйл явцтай холбон үзэж буй нь европ дахь барууныхны анхаарлыг ихээхэн татах боллоо.

Тэмцлийн ардчилсан хэлбэрийг баримжаагаа болгож буй даяарчлалыг эсэргүүцэгчдийн дийлэнх удирдагчид тактикийн үүднээс гудамжин дахь үйл ажиллагаанд олон түмнийг хамруулах чадвартай, тус хөдөлгөөнийг ихээхэн сонирхож буй янз бүрийн зүүний радикал бүлэглэлүүд болон анархистуудаас хөндийрөхийг төдийлөн яарахгүй байна. Хэдийгээр үзэл суртлын ялгаа байгаа хэдий ч даяарчлалын эсрэг хөдөлгөөний эгнээ улам нягтарсаар, үндэсний төдийгүй олон улсын түвшинд уг хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын чадвар сайжирсаар байна.

Даяарчлалыг эсэргүүцэгч байгууллагуудын материаллаг боломж өргөжихийн хэрээр төвлөрсөн санхүүжилтийн тогтолцоог бий болгох гэсэн оролдлогууд ч гарч байна. Тухайлбал, "Гринпис"-ийн Япон дахь салбар, европын зүүний намууд болон үйлдвэрчний эвлэлүүдийн фондоос тэдэнд дэмжлэг үзүүлж буй сувгууд ч тогтоогдоод байна.

АНУ дахь даяарчлалыг эсэргүүцэгчдийг гол ивээн тэтгэгчдийн тоонд "дэлхийн засгийн газар" байгуулах төлөвлөгөөг шийдвэртэй эсэргүүцэгч, саятан Д.Томпкинс орж байна. АТТАК буюу "иргэдийн тусын тулд санхүүгийн урсгалуудын татвар ноогдуулалтын төлөө нэгдэл"-ийг даяарчлалын эсрэг хөдөлгөөний илүү олон нийтийг хамарсан, нөлөө бүхий байгууллага хэмээн мэргэжилтнүүд үзэж байна. Үнэлгээгээр, тус байгууллага олон улсын түвшинд уг хөдөлгөөнийг нягтруулагч цөм нь болоход бэлэн байгаа аж.

1998 онд Париж хотноо 37 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан АТТАК нь Францад 200 гаруй бүс нутгийн хороод, Европ, Америк, Африк тивийн 29 улсад салбартай болоод байна. Неолиберал номлолыг эсэргүүцэгч уг байгууллага ҮДК-ийн нөлөөг хязгаарлах, улс бүхэн хөгжлийнхөө загварыг бие даан сонгох эрхтэй байх, ядуу буурай орнуудын өрийг хүчингүй болгохын төлөө үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа юм. Даяарчлалыг эсэргүүцэгчдийн үндсэн хэсгийг тэдгээрт нэгдэж буй "бусад жижиг бүлэглэлүүд болон гудамжны танхай этгээдүүд"-ээс тусгаарлах зайлшгүй шаардлагатайг Европын засгийн газрын хүрээнийхэн ч ойлгож эхэлж байна.

Барууныханы дунд даяарчлалыг эсэргүүцэгчдийн хөдөлгөөнийг "улс төрийн хэт даврах үзлийн шинэ хэлбэр" мэтээр үзэх, тэдний үйл ажиллагааг хэт даврагсад өөрсдийн зорилгод ашиглах, эсвэл шашны болон угсаатны радикал байгууллагуудтай даяарчлалыг эсэргүүцэгчид нэгдэх тухай асуудал нь үнэмшил багатай төдийгүй энэхүү хөдөлгөөнийг бүхэлд нь "алан хядагч байгууллага" мэтээр авч үзэх нь зүйд нийцэхгүй гэж мэргэжилтнүүд тайлбарлаж байна.